

МОНГОЛ ДАХЬ ГЭРЛЭГСДИЙН БОЛОВСРОЛЫН ИЖИЛ ТӨСТЭЙ БАЙДАЛ

Б.Наранчимэг, БНХАУ-ын Жилины Их Сургуулийн докторант, (米格, 吉林大学博士生)

Хураангуй

Энэ судалгааны ажлаар гэрлэлтийг боловсролын түвшинтэй холбон үзсэн бөгөөд Монгол Улсад 1990-ээд оноос хойш шинээр гэрлэсэн хосуудын боловсролын ижил төстэй байдал, түүний динамик хандлагыг судалж, хосуудын нас, боловсролын түвшин, бүс нутаг, гэрлэлтийн хэлбэр, хэв маягаар харьцуулан ялгаатай байдлыг тодорхойлох оролдлого хийсэн. Судалгааны ажил нь Монголын гэр бүлийн судалгааны салбарт судлагдаагүй асуудал болох гэрлэлт, түүний ижил төстэй байдлыг хосын сонголтод чухлаар нөлөөлөх боловсролын түвшинтэй холбон судалж байгаагаараа шинэлэг бөгөөд онол-практикийн ач холбогдолтой.

Судалгаанд Монгол Улсын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээллийг ашигласан тайлбар статистикийн шинжилгээг хийсэн. Судалгааны үр дүнгээс харахад боловсролоор ижил төстэй гэрлэлт 63.1 хувьтай байсан бөгөөд хосуудын нас, нөхөр/эхнэрийн боловсролын түвшин, гэрлэлтийн төрөл, хэлбэрээс хамаарч өөр хоорондоо ялгаатай байгаа нь ажиглагдлаа. Түүнчлэн динамик хандлага нь холбон судалсан үзүүлэлтүүдийн шинж чанараас хамааран харилцан ялгаатай хэлбэлзэл, хэв маягтай байв.

Түлхүүр үгс: Гэрлэлт, Боловсролын түвшин, Гэрлэлтийн ижил төстэй байдал, Боловсролоороо ижил төстэй гэрлэлт, Гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэл, Хүйсийн ялгаатай байдал

ҮНДЭСЛЭЛ

Эрдэмтэн судлаачдын тодорхойлсноор гэр бүл нь хүн төрөхтний оршин тогтнохуйн үндэс (Фихте), хүн амыг өсгөн үржүүлэх өвөрмөц холбоо (Фрейд), нийгмийн хөгжлийн анхдагч үүр (Кант) учир хүний нийгмийн түүхэн явцад бүрэлдэн тогтож⁴, түүний нөлөөнд автагдан бас түүний хөгжилд хүчтэй нөлөө үзүүлдэг харьцангуй бие даасан систем (Д.Тунгалаг) юм. Тийм ч учраас барууны болоод зүүний үе үеийн эрдэмтэн, судлаачид гэр бүлийн асуудлыг хавсарга болон тусгайлсан судалгааны чиглэл болгон судалж ирсэн. Гэр бүл бүрэлдэн тогтоход гэрлэлт чухал эсэх, гэр бүлийн тогтвортой байдал болон насан туршийн амьдралд хэрхэн нөлөөлдөг зэрэгтэй холбоотой асуудлууд нь гэр бүл судлалын амин чухал асуудлууд юм. Ялангуяа, хосын сонголт ба гэрлэх шийдвэртэй холбоотой судалгааны чиглэлд чухал байр суурь эзэлдэг.

Хэдийгээр ихэнх хүмүүс гэрлэлтийг хувь хүний хайр сэтгэл, мэдрэмжээс үүдэлтэй бие даасан шийдвэр гэж боддог боловч гэр бүлийн хос болох үйл явц нь нийгэмд тогтсон нэгэн жигд хэв маягийг дагадаг болох нь

түүхэн судалгааны явцад ажиглагдсан байна⁵. Хосоо олох асуудал нь “заяаны хань зам дээр” гэдэгчлэн цэвэр санамсаргүй хүлээлтийн шинж чанартай байхаасаа илүүтэй хосууд нийгмийн анги давхарга, яс үндэс, арьс өнгө, шашин шүтлэг, нас, боловсролын түвшин, гарал үүсэл зэрэг нийгэм, эдийн засгийн шинж чанаруудаараа ижил төсөөтэй байх хандлагатай байдаг. Тиймээс нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэн, судлаачид ХХ зууны эхний хагаст гэрлэлтийн шийдвэрийг нийгмийн бүтэц талаас нь илрүүлэн судалж байсан бол ХХ зууны сүүлийн хагасаас гэрлэлтийн ижил төсөөтэй (marital homogamy) болон ялгаатай байдлыг хэмжин судлахад түлхүүр анхаарах болжээ.

Монгол Улсын хувьд гэр бүл судлал хөгжлийн эхэн шатандаа⁶ яваа гэхэд болно. 1980-аад он хүртэл гэр бүлийн судалгаа нь түүх, угсаатан судлал, сурган хүмүүжүүлэх, анагаах ухаан, биологи зэрэг

⁴ Ф.Энгельс гэр бүлийг “Нийгмийн үзэгдэл”, Т.Намжил “Нийгмийн хөгжлийн бүтээгдэхүүн” гэж үзэж байсан нь нийгмийн хөгжлийн түүхэн явцад бүрэлдэн тогтдог гэсэн санааг илэрхийлж байна.

⁵ Tomas Katrnak, Martin Kreidl and Laura Fonadova, 2005. Trends in Educational Assortative Mating in Post-Socialist Central Europe: Czech Republic, Slovakia, Poland and Hungary between 1988 and 2000.

⁶ <<Германы монголч эрдэмтэн У.В.Баркман: “Нийгмийн хүртээл болсон нь ховор хэдий ч хүүхэд, залуучууд болон эмэгтэйчүүдийн асуудлыг тухайлан авч үзсэн судалгаанууд бас ч гэж хийгдсэн бөгөөд хачирхалтай нь эдгээрийн аль нь ч Монголын нийгмийн хамгийн жижиг хирнээ, хамгийн чухал бүрдүүлэгч хэсэг болох гэр бүлийн асуудлыг орхигдуулсан байдаг юм” хэмээн “Орчин үеийн Монголын тухай өгүүлүүд”-дээ тэмдэглэсэн байдаг>> Т.Намжил, 2014 он. Монгол гэр бүл. Бит Пресс ХХК. УБ 2014 он. Бүлэг 1. 11-р тал.

байгаль, нийгмийн шинжлэх ухаануудын судалгаанд хавсарга шинжтэй хөгжиж иржээ. Үүний шалтгааныг судлаач Д.Тунгалаг тайлбарлахдаа: *нэгд*, гэр бүл - нийгмийн холбооны ач холбогдлыг дутуу үнэлж, гэр бүлийг хувийн асуудал мэтээр үздэг субъектив хандлага давамгайлж байсан; *хоёрт*, гэр бүлийг шинжлэх ухааны судалгааны объект гэж үздэггүй байсан; *гуравт*, гэр бүлийн дотоод зөрчил, гэр бүл салалт зэргийг улсын нууцад хамруулж байсан үзэл сурталжсан байдлуудтай холбоотой гэсэн байна. 1980-аад оноос хойш гэр бүлийн асуудлаар эрдэмтэн, судлаачид сонирхон судалж эхэлснээс гадна улс орны нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй уялдан гэр бүлийн амьдралд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн болон бусад хүчин зүйлийг тодруулах шаардлагын үүднээс 1990-ээд оноос хойш судлаач, эрдэмтэд гэр бүлийн асуудлаар бие даасан судалгаа хийж эхэлжээ. Тодруулбал, 1980-аад оны дунд үеэс судлаач Д.Болдцэрэн /анагаах ухааны чиглэлээр/, Д.Тунгалаг /философи - ёс зүйн чиглэлээр/, Ц.Хурцбилэг /социологийн чиглэлээр/, 1990-ээд оноос Т.Намжил /түүхийн чиглэлээр/, Т.Бүрэнжаргал /социологийн чиглэлээр/ нар тодорхой чиглэлээр бие даасан судалгаа явуулж нэлээд бүтээл туурвисан байна. Хэдийгээр эдгээр судлаачид гэр бүлийн асуудлыг тодорхой салбарын хүрээнд судлахдаа тавьсан зорилго, судалгааны арга, шийдвэрлэсэн байдал нь өөр өөр боловч Монголд гэр бүл судлалыг шинээр хөгжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэсэн⁷.

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээр нийгэм, эдийн засгийн хямрал, өсөлт, өөрчлөлтүүдтэй холбоотой эерэг, сөрөг олон үр дагаврууд гэр бүлийн хөгжил, харилцаанд нөлөөлж байгаагаас эрдэмтэн, судлаачдын судалгааны чиглэл гэр бүлийн харилцаа, харилцааны дотоод асуудал, гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүй, хүүхдийн эрх, хүмүүжлийн асуудлуудад түлхүү чиглэж байна. Харин сүүлийн үед хийгдсэн *"Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал"*, *"Монголын залуучуудын нийгмийн дүр төрх: XX-XXI зууны зааг үе"* зэрэг зарим судалгаа, шинжилгээний бүтээлүүдэд гэрлэлтийн асуудлыг хөндсөн нь хавсарга шинжтэй

байгаа юм. Гэр бүлийн асуудлыг тал бүрээс нь нарийвчлан судална гэвэл асар их хүч, цаг хугацаа шаардагдана. Иймээс судлаач миний бие гэр бүлийн асуудлууд дотроос гэрлэлтийг хувь хүний нийгэмд эзлэх байр суурь, амьдралын хэтийн чиг хандлагыг тодорхойлох, хүн ам хөгжлийн бусад асуудлууд дахь чухал хүчин зүйл болох талаас нь онцгойлон анхаарч судлах нь зүйтэй гэж үзсэн.

Гэрлэлтийн хамгийн чухал асуудал бол сонголт юм. Амьдралын ханиа сонгох сонголтонд хайр сэтгэл гол үүрэгтэй боловч өнөөгийн нөхцөлд сонголт хэрхэн өөрчлөгдсөнийг судалж үзвэл өмч хөрөнгө, эрх мэдэл, албан тушаал зэрэг эдийн засгийн шалтгаантай янз бүрийн үндэслэлийг харгалзах болсон нь судалгаануудаас харагдаж байна⁸. Сайн сайхан амьдралыг бүрдүүлэхэд шаардлагатай бүх асуудал дээрээс зохицуулагддаг байсан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн өрсөлдөөнт нийгэмд шилжсэнээр иргэдийн дунд өндөр мэргэжил боловсролтой хүн ирээдүйд боломжийн сайхан амьдрах ба хэн ухаантай боловсролтой хүн л өрсөлдөгчөө ялан дийлнэ гэсэн үзэл бодол давамгайлах болжээ. Түүнчлэн Монголын залуучуудын нийгмийн дүр төрх судалгаа⁹-ны үр дүнгээс харахад өсөх ирээдүйтэй, мэдлэг чадвартай, боловсролтой байх нь ханиа сонгох чухал шалгуур (85.9 хувь нь чухал гэж үзсэн) болохоос гадна гэр бүлийн тогтвортой байдалд эзэмшсэн боловсрол, байр суурь чухлаар нөлөөлнө (47.3 хувь) гэж үзсэн байна.

Гэрлэлт, хосын сонголтод чухлаар нөлөөлж буй боловсролтой байх асуудалд 1990-ээд оноос хойш хүйсийн харьцаа алдагдаж, ялангуяа бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын дунд эмэгтэйчүүд давамгайлах (эрэгтэй:эмэгтэй – 1:2) хандлагатай болсон. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин харьцангуй өндөр болсны улмаас дийлэнх олонх нь (2/3-оос дээш хувь нь) өөрөөсөө доогуур боловсролтой нөхөртэй байна¹⁰. Дээд

⁷ Д.Тунгалаг, 2010 он. *Гэрлэлт, гэр бүлийн философи, ёс зүйн зарим асуудал*. УБ 2010 он. Soyombo publishing ХХК. Хэсэг 1. 59-68-р тал.

⁸ Д.Тунгалаг, 2010 он. *Гэрлэлт, гэр бүлийн философи, ёс зүйн зарим асуудал*. УБ 2010 он. Соёмбо Принтинг ХХК. Хэсэг 1. 75-р тал.

⁹ ШУА, ФСЭЗХ, 2012 он. *Монголын залуучуудын нийгмийн дүр төрх: XX-XXI зууны зааг үе. ХЗҮХ хэвлэх үйлдвэр*. УБ 2012 он. Бүлэг 6. 96-99-р тал.

¹⁰ МУ-ын ҮСХ, 2011. *Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: "Өрх, гэр бүлийн байдал" сэдэвчилсэн судалгаа*. Бүлэг 7. 90-р тал.

боловсролтой эмэгтэйчүүдэд өөрөөсөө дээгүүр юмуу ижил, ойролцоо түвшний боловсролтой эрэгтэйг сонгох боломж хязгаардлагдмал болж байгаагийн зэрэгцээ боловсрол нимгэн залуучууд өрх гэрээ авч явах чадвар буурч байгаа юм¹¹. Боловсрол дахь энэхүү хүйсийн ялгаатай байдал нь гэр бүлийн хосуудын нийгэмд эзлэх байр суурь, өрхийн эдийн засагт оруулж буй нөхөр/эхнэрийн үүрэг, санхүүгийн эрх мэдэл, улмаар гэр бүлийн тогтвортой байдал алдагдах, гэр бүл салах, дахин гэрлэх зэрэгт шууд ба шууд бусаар нөлөөлж байна. Тиймд гэрлэлтийг хосуудын боловсролын түвшинтэй холбон судлах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Судалгааны зорилго, ач холбогдол

Судалгааны ажлын гол зорилго нь Монгол Улсад 1990-ээд оноос хойш шинээр гэрлэсэн хосуудын гэрлэлт дэх боловсролын ижил төстэй байдал, түүний динамик хандлагыг судлаж, хосуудын нас, боловсролын түвшин, бүс нутаг, гэрлэлтийн хэлбэр, хэв маягуудаар зэрэгцүүлэн ялгаатай байдлыг тодорхойлоход оршино. Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- 1993-2013 оны хооронд шинээр гэрлэлтээ бүртгүүлсэн хосуудын боловсролын түвшинг хүйсийн хувьд харьцуулан судлах;
- Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн түвшин, динамик хандлагыг тодорхойлох;
- Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийг хосуудын нас, боловсролын түвшин, гэрлэлтийн төрөл, хэлбэр зэргээр зэрэгцүүлж, ялгаатай байдлыг илрүүлэх зэрэг болно.

Энэхүү судалгааны ажил нь Монголын гэр бүлийн судалгааны салбарт төдийлөн хангалттай судлагдаагүй асуудал болох гэрлэлт, түүний ижил төстэй байдлыг хосын сонголтод чухлаар нөлөөлөх боловсролын түвшинтэй холбон судалж байгаагаараа онол-практикийн ач холбогдолтой.

Судалгааны арга зүй, мэдээллийн эх үүсвэр

Судалгаанд Монгол Улсын УБЕГ-ийн гэрлэлтийн бүртгэлийн 1993-2013 оны

статистик мэдээллийг ашигласан бөгөөд энэ хугацаанд УБЕГ-т гэрлэлтээ бүртгүүлсэн 356915 хосын мэдээлэлд шинжилгээ хийв.

Үндсэн мэдээллийг шинжилгээнд бэлтгэхдээ статистик нэгтгэл, бүлэглэлтийн аргыг ашигласан ба гэрлэлтийн ижил төстэй байдлын шинжилгээнд тайлбар статистикийн шинжилгээний аргыг хэрэглэв.

ҮНДСЭН ҮР ДҮН

Гэрлэсэн хосуудын боловсролын түвшин

Монгол Улсын хэмжээнд 1993-2013 оны хооронд шинээр гэрлэлтээ бүртгүүлсэн нийт нөхрүүдийн 24.4 хувь нь суурь, 42.2 хувь нь бүрэн дунд, 19.8 хувь нь дээд, 8.5 хувь нь бага, 2.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 0.5 хувь нь техник мэргэжлийн боловсролтой байхад нийт эхнэрүүдийн 19.2 хувь нь суурь, 42.8 хувь нь бүрэн дунд, 26.3 хувь нь дээд, 5.7 хувь нь бага, 4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 0.4 хувь техник мэргэжлийн боловсролтой байв. Эндээс эхнэрүүдийн боловсролын түвшин нөхрүүдийнхээсээ харьцангуй өндөр байгаа нь батлагдаж байна. Үүнийг бүс нутгаар харьцуулж үзэхэд Улаанбаатар хотын гэрлэгсдийн хувьд бусад бүстэй харьцуулахад харьцангуй өндөр боловсролтой болох нь харагдаж байлаа. Тодруулбал, бүрэн дунд болон дээд боловсролтой нөхөр, эхнэрүүдийн хувийн жин аль аль нь Улаанбаатарт бусад бүсээс өндөр байна. Харин Хангайн болон Зүүн бүсэд гэрлэгсдийн боловсролын түвшин нөхөр ба эхнэрүүдийн аль алиных нь хувьд бусдаасаа харьцангуй доогуур байна (*Хавсралт Хүснэгт 1*).

Гэрлэгсдийн боловсролын түвшний динамик хандлагыг хүйс тус бүрээр харьцуулж үзэхэд, дээд боловсролтой нөхөр ба эхнэрүүдийн аль алиных нь хувийн жин өссөн хандлагатай байна. Дээд боловсролтой нөхрүүдийн хувь 2013 оны байдлаар 38.4 хувьд хүрсэн нь 1993 оны түвшинтэй харьцуулахад 5.7 дахин өссөн байхад дээд боловсролтой эхнэрүүдийн хувийн жин даруй 6.1 дахин өсөж 50 хувьд хүрсэн нь нэг талаас хосуудын боловсролын түвшин нэмэгдсэн мэт харагдавч, нөгөөтэйгүүр гэрлэлтээ хойшлуулж дээд боловсрол эзэмшсэнийхээ дараа гэрлэлтээ бүртгүүлэх хандлага зонхилох болсныг илтгэн харуулж байгаа юм (*Хавсралт Хүснэгт 2*).

¹¹ Б.Наранчимэг, 2006 он. Монголын хүн амын сэтгүүл, дугаар 6. Бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын жендерийн байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ. УБ хот.

Нийт гэрлэлттэй харьцуулахад хил дамнан гэрлэсэн хосуудын боловсролын түвшин харьцангуй өндөр байгаа нь ажиглагдла. Тодруулбал, хил дамнан гэрлэсэн нөхрүүдийн дийлэнх буюу 98.5 хувь, эхнэрүүдийн 87.7 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой байв. Энэ үзүүлэлтийг нийт гэрлэлтийн адил үзүүлэлттэй харьцуулахад харгалзан 34.1 ба 14.2 пунктээр өндөр байгаа юм (*Хавсралт Хүснэгт 2 & 3*).

Боловсролоор ижил төстэй гэрлэлт

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мэдээнд үндэслэн өрхийн тэргүүлэгч ба түүний эхнэр/нөхрийн боловсролын

түвшнийг зэрэгцүүлж үзэхэд боловсролын ижил төстэй байдал 68.1 хувьтай байсан. Уг үзүүлэлтийг 1993-2013 оны хооронд шинээр гэрлэлтээ бүртгүүлсэн хосуудын хувьд тооцож үзэхэд 63.1 хувь нь ижил боловсролын түвшинтэй байгаа нь тооллогын дүнгээс 5 пунктээр бага байлаа¹².

Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн өөрчлөлтийг хугацааны цуваагаар шинжилж үзвэл 2013 онд 60.1 хувь болж 1993 оны түвшнээс дөнгөж 0.6 пунктээр буурсан байгаа ч 1993-2013 оны хооронд 60.1-65.1 хооронд хэлбэлзэж байжээ. Энэ үзүүлэлт 2009 оноос хойш аажмаар тогтвортой буурч байгаа дүр зураг ажиглагдаж байна (*Зураг 1*).

Зураг 1. Нийт гэрлэлтэд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн эзлэх хувь, 1993-2013



Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Хүн амын боловсролын түвшин хүйсээр ялгаатай¹³ байгаа нь ижил түвшний боловсролтой хосуудын хувьд боловсролын түвшин тус бүрт аль нэг хүйс давамгайлах хандлагыг бий болгож байна. Монгол Улсын 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр ижил түвшний боловсролтой эхнэр, нөхрүүдийн хувьд ерөнхий боловсролоос бага түвшинд эрэгтэйчүүд давамгайлж байхад (хувийн жин¹⁴ нь тус бүр 35.7, 81.0) мэргэжлийн болон түүнээс дээш

боловсролын түвшинд эмэгтэйчүүд илүү (хувийн жин нь тус бүр харгалзан 36.8, 71.5) байсан¹⁵. Ийнхүү гэр бүлтэй хүн амын хувьд боловсролын түвшинд хүйсийн ялгаа нэлээд байгаа тул боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн үзүүлэлтийг хосуудын боловсролын түвшин тус бүрээр тооцон хүйсээр зэрэгцүүлж үзлээ (*Хүснэгт 1*).

¹² Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын мэдээлэл болон УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн судлаачийн өөрийн тооцоолол.

¹³ МУ-ын Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: “Боловсрол, бичиг үсгийн мэдлэг” сэдэвчилсэн судалгаа, 2011. 3-р бүлэг, 32 дугаар тал.

¹⁴ Энэ үзүүлэлт нь боловсролын тухайн түвшинд буй нөхөр/эхнэрийн нийт тоонд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жинг харуулна.

¹⁵ МУ-ын Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: “Жендэрийн тэгш байдал” сэдэвчилсэн судалгаа, 2011. 3-р бүлэг, 30 дугаар тал.

Хүснэгт 1. Боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь, нөхөр ба эхнэрийн боловсролын түвшин, гэрлэлтийн ижил төстэй байдлын үзүүлэлт (d)-ийн хүйсийн зөрүүгээр, 1993-2013

| Боловсролын түвшин | Боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь | | Зөрүү ($d = h_h^e - h_w^e$) |
|------------------------|--|-------------------|-------------------------------|
| | Нөхөр (h_h^e) | Эхнэр (h_w^e) | |
| Боловсролгүй | 54.2 | 53.5 | 0.6 |
| Бага | 45.5 | 68.4 | -23.0 |
| Суурь | 56.9 | 72.4 | -15.5 |
| Бүрэн дунд | 68.4 | 67.5 | 0.9 |
| Техник/мэргэжлийн | 52.6 | 62.6 | -9.9 |
| Тусгай мэргэжлийн дунд | 28.9 | 21.0 | 7.9 |
| Дээд | 72.8 | 54.8 | 18.0 |
| Нийт | 63.1 | 63.1 | 0 |

Тэмдэглэгээ: h_h^e – Нөхрүүдийн хувьд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь

h_w^e – Эхнэрүүдийн хувьд хувьд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь

Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.


Хүснэгт 1-ээс харахад боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь огт боловсролгүй болон бүрэн дунд боловсролын түвшинд хүйсийн хувьд онцын ялгаагүй байв.

Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь хосуудын аль алиных нь хувьд тусгай мэргэжлийн дунд боловсролын түвшинд хамгийн бага үзүүлэлттэй байгаа ч хүйсийн хувьд 7.9 пунктийн зөрүүтэйгээр нөхрүүдийн хувьд өндөр байна. Харин нөхрүүдийн хувьд уг үзүүлэлт дээд боловсролын түвшинд хамгийн өндөр 72.8 хувь (эхнэрийн дээд

боловсролын түвшинд харгалзах үзүүлэлтээс 18 пунктээр илүү) байхад эхнэрүүдийн хувьд бүрэн бус боловсролын түвшинд хамгийн өндөр 72.4 хувьтай (нөхрүүдийн бүрэн бус дунд боловсролын түвшинд харгалзах үзүүлэлтээс 15.5 пунктээр илүү) байлаа.

Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь боловсролын түвшин тус бүрд хүйсээр ялгаатай байгааг дээр дурдсан. Уг үзүүлэлтийн хүйсийн энэхүү зөрүүтэй байдлыг 1993-2013 оны динамикаар боловсролын түвшин тус бүрээр харьцуулж Зураг 2-т дүрслэн харуулав.

Зураг 2. Нөхөр ба эхнэрүүдийн хувьд тооцсон боловсролоор ижил төстэй гэрлэлтийн үзүүлэлтийн зөрүү (d), боловсролын түвшин ба гэрлэсэн оноор, 1993-2013



Тэмдэглэгээ: $d = h_h^e - h_w^e$

d - Боловсролоор ижил төстэй гэрлэлтийн үзүүлэлтийн хүйсийн зөрүүтэй байдал

h_h^e - Нөхрүүдийн хувьд тооцсон боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь

h_w^e - Эхнэрүүдийн хувьд тооцсон боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь

Дээд - Диломын дээд, Бакалавр, Магистр, Доктор болон түүнээс дээш

Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Хэдийгээр боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хүйсийн ялгаатай байдал нь огт боловсрол эзэмшээгүй хосуудын хувьд 1993-2013 оны дунджаар бусад боловсролын түвшин дэх хүйсийн ялгаанаас хамгийн бага байгаа боловч хугацааны туршид нэлээд хэлбэлзэлтэй байсан нь зургаас харагдаж байна.

Харин боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хүйсийн ялгаатай байдал нь 1993-2013 оны хооронд бүрэн дунд боловсролын түвшинд тогтвортойгоор хамгийн бага түвшинд байжээ.

Уг үзүүлэлт 1993-2009 оны хооронд эрэгтэйчүүдэд бага зэрэг давамгайл байсан бол 2009 оноос хойш эмэгтэйчүүдийн бүрэн дунд боловсролын түвшинд давамгайлах хандлагатай болсон байна. Хоёулаа дээд боловсролтой хосуудын хувьд боловсролын түвшнээр ижил төстэй гэрлэлтийн хувь судлагдсан хугацааны туршид эрэгтэйчүүд давамгайл байгаагаас гадна хүйсийн ялгаатай байдал улам нэмэгдсээр байна. Энэ нь дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн

жин эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү их нэмэгдэж байгаатай холбоотой. Харин бүрэн бус дунд болон бага боловсролын түвшнээрээ ижил хосуудын хувьд уг үзүүлэлт судлагдсан хугацааны туршид эмэгтэйчүүдэд давамгайл байжээ.

Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийг хосуудын гэрлэх үеийн насаар харьцуулж үзлээ. Гуч хүртэлх насныхны залуучуудын хувьд (30 хүртэлх насны нөхрүүдэд 64.2 хувь, эхнэрүүдэд 63.9 хувь) 30 ба түүнээс насныхантай (30 ба түүнээс дээш насны нөхрүүдэд 59.5 хувь, эхнэрүүдэд 58.8 хувь) харьцуулахад боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь харьцангуй өндөр байгаа нь хүйсийн хувьд онцын ялгаагүй байв. Үүнийг 1993-2013 оны динамикаар нас ба хүйсээр зэрэгцүүлж Зурагт 3-т дүрслэн харууллаа.

Судлагдаж буй хугацааны туршид залуучуудын дунд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь 30 ба түүнээс дээш насныхантай харьцуулахад 3-12.4 пунктийн хэлбэлзэлтэйгээр ямагт өндөр байсан нь ажиглагдсан.

Зураг 3. Нийт гэрлэлтэд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн эзлэх хувь, гэрлэх үеийн хосуудын нас ба гэрлэсэн оноор (1993-2013)



Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувийн жинг бүс нутгаар зэрэгцүүлж үзэхэд Улаанбаатарт бусад бүсээсээ хамгийн өндөр (65.9 хувь) байхад Төвийн бүсэд хамгийн бага (59.4 хувь) байв (Хавсралт Хүснэгт 1).

Хос хоёр хоёулаа анх удаагаа гэрлэж байгаа болон аль нэг нь дахин гэрлэж буй хосуудын хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь харилцан ялгаатай байгааг Зураг 4-өөс харж болно.

Зураг 4. Нийт гэрлэлтэд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн эзлэх хувь, гэрлэлтийн төрөл ба гэрлэсэн оноор (1993-2013)



Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Анхны гэрлэлтийн хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь 1993-2013 оны хооронд харьцангуй тогтвортой (60.4-65.4 хувь) буюу 5 пунктийн хэбэлзэлтэй байсан бол дахин гэрлэсэн хосуудын хувьд боловсролын ижил төстэй гэрлэлтийн үзүүлэлт 45.7-61.9 хооронд нэлээд хэлбэлзэлтэй байжээ. Судлагдаж буй хугацааны дунджаар анхны гэрлэлт дэх боловсролоор ижил төстэй гэрлэлтийн үзүүлэлт 63.3 хувьтай байхад

дахин гэрлэсэн хосуудын хувьд уг үзүүлэлт 56.6 хувьтай байв (Хавсралт Хүснэгт 4).

Зураг 5-д боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувийг хил дамнасан гэрлэлтийн статусаар 1993-2013 оны динамикаар дүрслэн харуулжээ. Зургаас харахад улс доторх болон хил дамнасан гэрлэлтийн хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь нэлээд ялгаатай байна.

Зураг 5. Нийт гэрлэлтэд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн эзлэх хувь, хил дамнасан гэрлэлтийн байдал ба гэрлэсэн оноор (1993-2013)



Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Улс дотроо гэрлэсэн хосуудын хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь судлагдаж буй хугацааны туршид 60.3-65.4 хувийн хооронд нэлээд тогтвортой, дунжаар 63.3 хувьтай байсан бол хил дамнасан гэрлэгсдийн хувьд дунджаар 48.9 хувьтай байснаас гадна хугацааны туршид 26.3-66.7 хувийн хооронд маш хэлбэлзэлтэй байв. Энэ

нь хил дамнасан гэрлэж буй монгол иргэдийн боловсролын түвшнээс гадна тэдний гадаад хосын боловсролын түвшнээс аль алианаас нь шалтгаалж байна.

Тиймээс боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувийг хосуудын боловсролын түвшнээр зэрэгцүүлж үзлээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь, нөхөр ба эхнэрийн боловсролын түвшин, хил дамнасан гэрлэлтийн байдлаар, 1993-2013

| Боловсролын түвшин | Боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь | | | |
|------------------------|--|-------------------|--------------------|-------------------|
| | Хил дамнасан гэрлэлт | | Улс доторх гэрлэлт | |
| | Нөхөр (h_h^e) | Эхнэр (h_w^e) | Нөхөр (h_h^e) | Эхнэр (h_w^e) |
| Боловсролгүй | 11.6 | 0.8 | 54.5 | 59.7 |
| Бага | - | - | 45.5 | 68.9 |
| Суурь | 13.5 | 12.5 | 56.9 | 72.4 |
| Бүрэн дунд | 57.1 | 70.6 | 68.7 | 67.5 |
| Техник/мэргэжлийн | 8.2 | 20.8 | 54.1 | 63.2 |
| Тусгай мэргэжлийн дунд | 13.9 | 8.9 | 29.1 | 21.2 |
| Дээд | 40.7 | 41.3 | 74.0 | 55.2 |
| Нийт | 48.9 | 48.9 | 63.3 | 63.3 |

Тэмдэглэгээ: h_h^e – Нөхрүүдийн хувьд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь

h_w^e – Эхнэрүүдийн хувьд хувьд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь

Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Улс дотроо гэрлэсэн хосуудын хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь эрэгтэйчүүдийн дээд боловсролын түвшинд (74 хувь), эмэгтэйчүүдийн бүрэн бус боловсролын түвшинд хамгийн өндөр (72.4 хувь), харин нөхөр ба эхнэрүүдийн аль алиных нь хувьд тусгай мэргэжлийн дунд боловсролын түвшинд хамгийн бага (харгалзан 29.1 ба 21.2 хувь) байгаа нь нийт гэрлэсэн хосуудын үзүүлэлттэй ойролцоо түвшинд байгаа юм. Гэтэл хил дамнан гэрлэгсдийн хувьд нэлээд ялгаатай байдал ажиглагдлаа. Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь хил дамнан гэрлэсэн нөхрүүдийн ба эхнэрүүдийн аль алиных нь хувьд бүрэн дунд боловсролын түвшинд (харгалзан 57.1 ба 70.6 хувь) хамгийн өндөр байсан бол эсрэгээрээ нөхрүүдийн техникийн болон мэргэжлийн боловсролын түвшинд (8.2 хувь), харин огт боловсрол эзэмшээгүй эхнэрүүдийн хувьд (0.8 хувь) хамгийн бага үзүүлэлттэй байв.

Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь хил дамнан гэрлэгсдийн хувьд 48.9 байгаа нь нийт гэрлэлтийн хувьд тооцсон уг үзүүлэлттэй харьцуулахад даруй 12.2 пунктээр доогуур үзүүлэлт болж байна. Энэ нь хил дамнан гэрлэж буй монгол иргэдийн хүйсээс ихээхэн шалтгааж байгааг судалгааны үр дүн харуулж байна. Хил дамнан гэрлэж буй монгол эрэгтэйчүүдийн хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлт 64 хувьтай байхад гадаад иргэдтэй гэрлэсэн

монгол эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 47.8 хувь байгаа юм (Хавсралт Хүснэгт 3).

ДҮГНЭЛТ

Монгол улс хөгжихийн хэрээр хүн амын гэрлэлтийн түүхэнд тодорхой өөрчлөлтүүд гарч байна. Шилжилтийн эхэн үе болох 1990-ээд оны эхээр өмч хувьд шилжиж, нийгэм, эдийн засгийн хямрал нүүрлэж байсан үед өрх гэр бүлийн түвшинд ядуурал, ажилгүйдэл газар авч байсантай холбоотойгоор эцэг, эхчүүд хөвгүүдээ сургууль завсардуулж мал маллуулах эсвэл ажил хийлгэх сонирхол их болсоноос гадна боловсролын хувьд оксидуудаа харьцангуй илүү хөрөнгө оруулалт хийснээр бүрэн дунд ба түүнээс дээш боловсролын түвшинд хүйсийн тэнцвэрт байдал алдагдсан. Энэ нь залуучуудын гэрлэлтийн шийдвэр ба хосоо сонгох сонголтод тодорхой хэмжээний нөлөөг үзүүлж, улмаар гэр бүлийн хосуудын нийгэмд эзлэх байр суурь, өрхийн эдийн засагт оруулж буй нөхөр/эхнэрийн үүрэг, санхүүгийн эрх мэдэл, гэр бүлийн тогтвортой байдал алдагдах, гэр бүлийн задрал зэрэгт нөлөөлж байна.

Энэ судалгааны ажлаар Монгол улсад 1990-ээд оноос хойш шинээр гэрлэсэн хосуудын гэрлэлт дэх боловсролын ижил төстэй байдал, түүний динамик хандлагыг судалж, хосуудын нас, боловсролын түвшин, бүс нутаг, гэрлэлтийн хэлбэр, хэв маягуудаар

зэрэгцүүлж ялгаатай байдлыг тодорхойлох гол зорилго дэвшүүлсэн. Түүнчлэн судалгаа Монголын гэр бүлийн судалгааны салбарт судлагдаагүй асуудал болох гэрлэлт, түүний ижил төстэй байдлыг хосын сонголтод чухлаар нөлөөлөх боловсролын түвшинтэй холбон судалж байгаагаараа онол-практикийн ач холбогдолтой болсон.

Судалгааны үр дүнгээс үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийсэн. Үүнд:

- ✓ Монгол улсын хэмжээнд 1993-2013 оны хооронд шинээр гэрлэлтээ бүртгүүлсэн нийт хосуудын боловсролын түвшинг харьцуулж үзэхэд эхнэрүүдийн боловсролын түвшин нөхрүүдийнхээсээ харьцангуй өндөр байв. Түүнчлэн дээд боловсролтой нөхрүүдийн хувь 2013 оны байдлаар 38.4 хувьд хүрсэн нь 1993 оны түвшинтэй харьцуулахад 5.7 дахин, дээд боловсролтой эхнэрүүдийн хувийн жин даруй 6.1 дахин өсөж 50 хувьд хүрсэн нь нэг талаас хосуудын боловсролын түвшин нэмэгдсэн мэт харагдавч, нөгөөтэйгүүр гэрлэлтээ хойшлуулж дээд боловсрол эзэмшсэнийхээ дараа гэрлэлтээ бүртгүүлэх хандлага зонхилох болсныг илтгэн харуулж байгаа юм.
- ✓ Боловсролоор ижил төстэй гэрлэлтийн нийт гэрлэлтэд эзлэх хувийн жинг 1993-2013 оны хооронд шинээр гэрлэлтээ бүртгүүлсэн хосуудын хувьд тооцож үзэхэд 63.1 хувь боловсролоор ижил төстэй хүнтэй гэрлэсэн байв.
- ✓ Боловсролоор ижил төстэй гэрлэлтийг хосуудын боловсролын түвшнээр зэрэгцүүлж үзэхэд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хүйсийн ялгаатай байдал нь огт боловсрол эзэмшээгүй хосуудын хувьд 1993-2013 оны дунджаар бусад боловсролын түвшин дэх хүйсийн ялгаанаас хамгийн бага байгаа боловч хугацааны туршид нэлээд хэлбэлзэлтэй байжээ. Харин боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хүйсийн ялгаатай байдал нь 1993-2013 оны хооронд бүрэн дунд боловсролын түвшинд тогтвортойгоор хамгийн бага түвшинд байсан байна. Уг үзүүлэлт 1993-2009 оны хооронд эрэгтэйчүүдэд бага зэрэг давамгай байсан бол 2009 оноос хойш эмэгтэйчүүдийн бүрэн дунд боловсролын түвшинд давамгайлах хандлагатай болсон байна. Хоёулаа дээд боловсролтой хосуудын хувьд боловсролын түвшнээр ижил төстэй гэрлэлтийн хувь судлагдсан хугацааны туршид эрэгтэйчүүд давамгай байгаагаас гадна хүйсийн ялгаатай байдал улам нэмэгдсээр байна. Энэ нь дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү их нэмэгдэж байгаагаар холбоотой. Харин бүрэн бус дунд болон бага боловсролын түвшнээрээ ижил хосуудын хувьд уг үзүүлэлт судлагдсан хугацааны туршид эмэгтэйчүүдэд давамгай байжээ.
- ✓ Боловсролоороо ижил төстэй гэрлэлтийг хосуудын гэрлэх үеийн насаар харьцуулж үзэхэд 30 хүртэлх насныхны залуучуудын 30 ба түүнээс насныхантай харьцуулахад харьцангуй өндөр байв. Энэ хэв маяг хүйсийн хувьд онцын ялгаагүй байлаа.
- ✓ Хос хоёр хоёулаа анх удаагаа гэрлэж байгаа болон аль нэг нь дахин гэрлэж буй хосуудын хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь нэлээд ялгаатай байв. Анхны гэрлэлтийн хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь 1993-2013 оны хооронд харьцангуй тогтвортой (60.4-65.4 хувь) буюу 5 пунктийн хэбэлзэлтэй байсан бол дахин гэрлэсэн хосуудын хувьд боловсролын ижил төстэй гэрлэлтийн үзүүлэлт 45.7-61.9 хооронд нэлээд хэлбэлзэлтэй байжээ.
- ✓ Улс дотроо гэрлэсэн хосуудын хувьд боловсролоороо ижил төстэй гэрлэлтийн хувь судлагдаж буй хугацааны туршид 60.3-65.4 хувийн хооронд нэлээд тогтвортой, дунджаар 63.3 хувьтай байсан бол хил дамнан гэрлэгсдийн хувьд дунджаар 48.9 хувьтай байснаас гадна хугацааны туршид 26.3-66.7 хувийн хооронд маш хэлбэлзэлтэй байв.
- ✓ Хил дамнан гэрлэгсдийн хувьд

боловсролын ижил төстэй байдал монгол иргэдийн хүйсээс хамааран нэлээд ялгаатай байв. Хил дамнан гэрлэсэн Монгол эрэгтэйчүүдийн хувьд боловсролоор ижил төстэй гэрлэлт 64 хувьтай байхад гадаад иргэдтэй гэрлэсэн монгол эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 47.8 хувь байгаа юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд айл гэрийн ноён нуруу болох Монгол эрэгтэйчүүдийн боловсролын түвшин эхнэрүүдийнхээсээ доогуур байгааг анхаарч цаашид эрэгтэйчүүдийн боловсролд чиглэсэн бодлогын арга хэмжээг макро болон микро түвшинд аль алинд нь авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эрэгтэйчүүдийн боловсролын түвшин эхнэрүүдээсээ дутахгүй, өндөр болсноор наанадаж хосын сонголт, гэрлэлтийн шийдвэр, гэрлэлтийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлөхөөс гадна өрхийн амьжиргааны түвшин, өрхийн гишүүдийн хоорондын харилцаа, хүүхдийн боловсрол, хүмүүжил зэрэг нийгэм, эдийн засгийн олон талын эерэг нөлөөллүүд бий болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Б.Наранчимэг, 2006 он. Монголын хүн амын сэтгүүл, дугаар 6. Бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын жендэрийн байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ. УБ хот.
- Д.Тунгалаг, 2010 он. Гэрлэлт, гэр бүлийн философи, ёс зүйн зарим асуудал. УБ 2010 он. Соёмбо Принтинг ХХК. Хэсэг 1. 59-75-р тал.
- МУ-ын Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: "Өрх, гэр бүлийн байдал" сэдэвчилсэн судалгаа, 2011. "BCI" Хэвлэлийн компани. Бүлэг 7
- МУ-ын Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: "Боловсрол, бичиг үсгийн мэдлэг" сэдэвчилсэн судалгаа, 2011. 3-р бүлэг, 32 дугаар тал.
- МУ-ын Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: "Жендэрийн тэгш байдал" сэдэвчилсэн судалгаа, 2011. 3-р бүлэг, 30 дугаар тал.
- НХХЯ, ФСЭЗХ, НҮБХАС, УБИС, 2010 он. Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, судалгааны тайлан. УБ 2010 он. Соёмбо Принтинг ХХК.
- Т.Намжил, 2014 он. Монгол гэр бүл. Бит Пресс ХХК. УБ 2014 он. Бүлэг 1. 11-р тал.
- ШУА, ФСЭЗХ, 2012 он. Монголын залуучуудын нийгмийн дүр төрх: XX-XXI зууны зааг үе. ХЗҮХ хэвлэх үйлдвэр. УБ 2012 он. Бүлэг 6. 96-99-р тал.
- Tomas Katrnak, Martin Kreidl and Laura Fonadova, 2005. Trends in Educational Assortative Mating in Post-Socialist Central Europe: Czech Republic, Slovakia, Poland and Hungary between 1988 and 2000.

ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Гэрлэсэн хосуудын хувийн жин, гэрлэлтээ бүртгүүлсэн бүс нутаг ба боловсролын түвшний сонгосон үзүүлэлтүүдээр, 1993-2013

| Сонгосон үзүүлэлтүүд | Гэрлэлтээ бүртгүүлсэн бүс нутаг | | | | | Бүгд |
|------------------------------------|---------------------------------|---------------|---------------|---------------|----------------|----------------|
| | Баруун | Хангай | Төв | Зүүн | Улаанбаатар | |
| Боловсролын түвшний зөрүү | | | | | | |
| Ижил боловсролтой | 63.5 | 61.3 | 59.4 | 59.6 | 65.9 | 63.1 |
| Нөхөр нь илүү боловсролтой | 9.9 | 10.8 | 11.1 | 11.5 | 11.5 | 11.1 |
| Эхнэр нь илүү боловсролтой | 26.6 | 27.9 | 29.5 | 28.9 | 22.6 | 25.9 |
| Нөхрийн боловсролын түвшин | | | | | | |
| Боловсролгүй | 2.0 | 3.1 | 1.5 | 1.9 | 0.8 | 1.7 |
| Бага | 14.4 | 16.3 | 9.8 | 13.2 | 1.1 | 8.5 |
| Суурь | 37.7 | 33.4 | 30.4 | 37.8 | 10.2 | 24.4 |
| Бүрэн дунд | 29.3 | 34.7 | 40.9 | 34.3 | 52.6 | 42.2 |
| Техник/мэргэжлийн | 1.5 | 0.4 | 0.6 | 0.5 | 0.2 | 0.5 |
| Тусгай мэргэжлийн дунд | 3.1 | 2.2 | 3.2 | 2.5 | 3.1 | 2.9 |
| Дээд | 12.0 | 9.9 | 13.7 | 9.6 | 31.9 | 19.8 |
| Эхнэрийн боловсролын түвшин | | | | | | |
| Боловсролгүй | 1.8 | 2.9 | 1.2 | 1.7 | 1.2 | 1.7 |
| Бага | 10.2 | 11.6 | 5.6 | 8.0 | 0.6 | 5.7 |
| Суурь | 32.5 | 27.7 | 23.2 | 31.6 | 6.3 | 19.2 |
| Бүрэн дунд | 30.0 | 37.5 | 45.2 | 39.5 | 49.6 | 42.8 |
| Техник/мэргэжлийн | 1.3 | 0.4 | 0.5 | 0.5 | 0.2 | 0.4 |
| Тусгай мэргэжлийн дунд | 5.2 | 3.8 | 4.4 | 4.0 | 3.4 | 4.0 |
| Дээд | 19.0 | 16.0 | 20.0 | 14.7 | 38.8 | 26.3 |
| Нийт | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Гэрлэсэн хосуудын тоо | 51,720 | 74,910 | 59,772 | 24,718 | 145,795 | 356,915 |

Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Хүснэгт 2. Гэрлэсэн хосуудын хувийн жин, боловсролын түвшний сонгосон үзүүлэлтүүдээр, 1993, 1998, 2003, 2008, 2013

| Сонгосон үзүүлэлтүүд | Гэрлэлтээ бүртгүүлсэн он | | | | | Бүгд 1993-2013 |
|------------------------------------|--------------------------|---------------|---------------|---------------|---------------|-------------------|
| | 1993 | 1998 | 2003 | 2008 | 2013 | |
| Боловсролын түвшний зөрүү | | | | | | |
| Ижил боловсролтой | 60.7 | 64.5 | 62.7 | 64.0 | 60.1 | 63.1 |
| Нөхөр нь илүү боловсролтой | 13.4 | 12.0 | 11.7 | 10.2 | 10.9 | 11.1 |
| Эхнэр нь илүү боловсролтой | 25.9 | 23.6 | 25.5 | 25.8 | 29.1 | 25.9 |
| Нөхрийн боловсролын түвшин | | | | | | |
| Боловсролгүй | 11.4 | 0.9 | 1.1 | 0.7 | 2.1 | 1.7 |
| Бага | 4.0 | 5.6 | 11.0 | 8.7 | 6.0 | 8.5 |
| Суурь | 21.9 | 36.6 | 34.6 | 17.3 | 10.8 | 24.4 |
| Бүрэн дунд | 47.0 | 43.3 | 34.4 | 46.6 | 38.7 | 42.2 |
| Техник/мэргэжлийн | 1.4 | 1.1 | 0.6 | 0.1 | 1.2 | 0.5 |
| Тусгай мэргэжлийн дунд | 7.6 | 3.9 | 3.0 | 1.8 | 2.9 | 2.9 |
| Дээд | 6.7 | 8.7 | 15.3 | 24.8 | 38.4 | 19.8 |
| Эхнэрийн боловсролын түвшин | | | | | | |
| Боловсролгүй | 9.4 | 1.0 | 1.2 | 0.9 | 1.8 | 1.7 |
| Бага | 2.9 | 4.2 | 8.7 | 4.8 | 2.8 | 5.7 |
| Суурь | 15.8 | 30.1 | 28.9 | 12.3 | 7.2 | 19.2 |
| Бүрэн дунд | 50.5 | 46.6 | 35.6 | 47.2 | 34.2 | 42.8 |
| Техник/мэргэжлийн | 1.0 | 1.0 | 0.5 | 0.1 | 1.3 | 0.4 |
| Тусгай мэргэжлийн дунд | 12.3 | 6.8 | 4.6 | 2.0 | 2.8 | 4.0 |
| Дээд | 8.2 | 10.3 | 20.5 | 32.6 | 50.0 | 26.3 |
| Нийт | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Гэрлэсэн хосуудын тоо | 3,518 | 12,276 | 20,843 | 33,624 | 17,106 | 356,915 |

Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Хүснэгт 3. Хил дамнан гэрлэсэн хосуудын хувийн жин, боловсролын түвшний сонгосон үзүүлэлтүүд ба хүйсээр, 1993-2013

| Сонгосон үзүүлэлтүүд | Хил дамнан гэрлэгчдийн хүйс | | Бүгд |
|------------------------------------|-----------------------------|-----------------------------|--------------|
| | Монгол нөхөр + Гадаад эхнэр | Монгол Эхнэр + Гадаад нөхөр | |
| Боловсролын түвшний зөрүү | | | |
| Ижил боловсролтой | 64 | 47.8 | 48.9 |
| Нөхөр нь илүү боловсролтой | 14.4 | 27.3 | 26.5 |
| Эхнэр нь илүү боловсролтой | 21.6 | 24.9 | 24.7 |
| Нөхрийн боловсролын түвшин | | | |
| Боловсролгүй | 5.3 | 0.3 | 0.7 |
| Бага | 1.2 | 0.1 | 0.2 |
| Суурь | 1.6 | 0.5 | 0.6 |
| Бүрэн дунд | 39.5 | 58.1 | 56.9 |
| Техник/мэргэжлийн | 0.5 | 1 | 0.9 |
| Тусгай мэргэжлийн дунд | 2.6 | 1.8 | 1.8 |
| Дээд | 49.3 | 38.2 | 39 |
| Эхнэрийн боловсролын түвшин | | | |
| Боловсролгүй | 0.5 | 10.1 | 9.5 |
| Бага | 0.2 | 2.3 | 2.2 |
| Суурь | 0.7 | 0.6 | 0.6 |
| Бүрэн дунд | 41.2 | 46.4 | 46.1 |
| Техник/мэргэжлийн | 0.2 | 0.4 | 0.4 |
| Тусгай мэргэжлийн дунд | 1.9 | 3 | 2.9 |
| Дээд | 55.3 | 37.3 | 38.4 |
| Нийт | 100 | 100 | 100 |
| Гэрлэсэн хосуудын тоо | 430 | 6,182 | 6,612 |

Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Хүснэгт 4. Боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь, нөхөр ба эхнэрийн боловсролын түвшин ба гэрлэлтийн төрлөөр, 1993-2013

| Боловсролын түвшин | Боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь | | | |
|------------------------|--|-------------------|-------------------|-------------------|
| | Хосуудын аль алиных нь хувьд анхны гэрлэлт | | Дахин гэрлэлт | |
| | Нөхөр (h_n^e) | Эхнэр (h_w^e) | Нөхөр (h_n^e) | Эхнэр (h_w^e) |
| Боловсролгүй | 54.2 | 54.8 | 52.8 | 31.9 |
| Бага | 45.6 | 68.8 | 34.3 | 43.2 |
| Суурь | 57.1 | 72.5 | 45.1 | 63.1 |
| Бүрэн дунд | 68.9 | 67.7 | 54.2 | 63.4 |
| Техник/мэргэжлийн | 54.3 | 63.9 | 24.5 | 35.1 |
| Тусгай мэргэжлийн дунд | 29.2 | 21.3 | 25.3 | 16.5 |
| Дээд | 73.1 | 54.5 | 68.9 | 58.8 |
| Нийт | 63.3 | 63.3 | 56.6 | 56.6 |

Тэмдэглэгээ: h_n^e – Нөхрүүдийн хувьд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь

h_w^e – Эхнэрүүдийн хувьд хувьд боловсролоор ижил төстэй гэрлэлтийн хувь

Эх үүсвэр: МУ-ын УБЕГ-ын 1993-2013 оны гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.